

Гадаад Харилцагчдынхаа Анхааралд


Банкны харилцах данс нээлгэхэд дараах бичиг баримт зайлшгүй шаардлагатайг анхаарна уу.
Данс нээлгэхээр ирэхдээ дурдсан зүйлсийг биедээ авч очоорой.

«Банкны данс нээлгэхэд шаардлагатай бичиг баримтууд»

Оршин суух үнэмлэх (Загвар)



Эх сурвалж: Японы Цагаачлалын Товчоо Цахим хуудас



Биеийн байцаалт

- Биеийн байцаалт нь эзэмшигчийн фото зураг, эзэмшигчийн нэр, (Япон улс дахь) Хаяг болон төрсөн огноог зайлшгүй харуулсан байна.

Жишээ нь:

- Оршин суух үнэмлэх
- Байнгын оршин суугчийн тусгай гэрчилгээ
- Хувийн дугаарын карт
- Паспорт

* Данс нээх явцад хүсэлт гаргагчийн Японд оршин суух хугацааг баталгаажуулж шалгах магадлалтай. Хүсэлт гаргагчаас нэгээс илүү биеийн байцаалт үзүүлэхийг шаардаж магадгүй.

Дардас тамга эсвэл гарын үсэг

- Данс нээх үед, өргөдлийн маягт нь хүсэлт гаргагчийн дардас тамгаар хүчин төгөлдөр болно. Ихэнх санхүүгийн байгууллага гарын үсгийг хоёрдогч сонголт болгон зөвшөөрдөг болохыг анхаарна уу.
- Та дардсаа захиалах үедээ, банкны гүйлгээний шаардлагыг хангасан байх ёстойг дэлгүүрийнхэнд сануулаарай.

Бусад шаардлагууд

- Банкны данс нээлгэхээр хандахдаа, ажлын үнэмлэх эсвэл хүсэлт гаргагчийн ажил эрхлэлтийн байдлыг тодорхойлох өөр бичиг баримт авч ирнэ үү.
- Данс нээх явцад хүсэлт гаргагчийн ажил эрхэлдэг газар луу утсаар холбогдох баталгаажуулах магадлалтайг анхаарна уу.
- Япон хэлний тусламж шаардлагатай хүсэлт гаргагч нь өөрийн ажлын хүрээллийн зэрэг өөр хүнээс туслалцаа хүсэх хэрэгтэй.
- Оюутан бол оюутны үнэмлэхээ авч очих шаардлагатай.

Харилцах дансыг худалдах эсвэл худалдан авах нь ял шийтгэл хүлээхүйц хэрэг зөрчил юм!

- Харилцах данс худалдах эсвэл худалдан авах (жишээ нь: харилцах дансны тооцооны дэвтэр эсвэл ATM-ээс мөнгө авдаг бэлэн мөнгөний карт зарах эсвэл авах) нь Япон улсын хуулиар хориотой бөгөөд худалдагч болон худалдан авагч хоёул шийтгэл хүлээнэ.
- Хэрвээ та оршин суух хугацаа дууссан гэх мэт шалтгаанаар эх орон руугаа буцахаар болсон бол банкны дансыг хууль бусаар ашиглахаас урьдчилан сэргийлэх үүднээс дансаа хаалгаарай.



一般社団法人
全国銀行協会